

Тойм ба үндэслэл

Үзүүлэлт	22. СББӨ-ийн хамгаалалтад хяналт тавихад иргэний нийгэм хэр зэрэг хувь нэмэр оруулдаг эсэх.	
Үнэлгээний хүчин зүйлүүд	Энэхүү үзүүлэлтийг оролцогч талуудаар хянуулж тайлагнуулсан үндэсний түвшний гурван хүчин зүйл дээр үндэслэн үнэлдэг	
	22.1 Холбогдох олон нийт, бүлгүүд, хувь хүмүүст СББӨ-ийг хамгаалах хөтөлбөр, арга хэмжээний талаар шинжлэх ухаан, техник, урлагийн чиглэлийн судалгаа явуулах, хяналт тавих таатай орчин бүрдүүлэх.	OD 85, OD 151, OD 153(b)(ii)
	22.2 ТББ болон иргэний нийгмийн бусад байгууллагуудад СББӨ-ийг хамгаалах хөтөлбөр, арга хэмжээний талаар шинжлэх ухаан, техник, урлагийн чиглэлийн судалгаа хийх, хяналт тавихад таатай орчин бүрдүүлсэн байх.	OD 83, OD 151, OD 153(b)(ii)
	22.3 Эрдэмтэд, шинжээчид, судалгааны байгууллага, мэргэжлийн төвүүдэд СББӨ-ийг хамгаалах хөтөлбөр, арга хэмжээг хянах, шинжлэх ухаан, техник, урлагийн чиглэлийн судалгаа хийх таатай орчин бүрдүүлдэг байх.	OD 83, OD 84, OD 151, OD 153(b)(ii)

<p>ТХЗ болон бусад холбогдох үзүүлэлтүүд</p>	<p>Тогтвортой хөгжлийн зорилтууд: Үзүүлэлт 21-ийн нэгэн адил энэхүү үзүүлэлт нь "Бүх түвшинд хариуцлагатай, хүртээмжтэй, оролцоо өндөртэй, төлөөллийн шийдвэр гаргалтыг хангах" ТХЗ Зорилт 16.7-ыг болон ТХЗ-ын 17.17 зорилт буюу "Төр, иргэд, хувийн хэвшил, иргэний нийгмийн үр дүнтэй түншлэлийг хөхүүлэн дэмжих, туслалцаа үзүүлэх"-ийг дэмжиж байна. Бүх шалгуур үзүүлэлтүүдийн нэгэн адил энэхүү үзүүлэлт нь ТХЗ-ын 11.4 болох "дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах, хамгаалалтын хүчин чармайлтыг бэхжүүлэх" зорилтод нийцэж байдаг.</p> <p>Бусад үзүүлэлтүүдийн хамаарал: Үзүүлэлт 21 нь СББӨ-ийн хамгаалалтын үйл ажиллагааг явуулахад оролцох олон янзын оролцогчдын аль болох өргөн оролцоог илэрхийлдэг бол энэ үзүүлэлтийн гол анхаарал нь тэдний СББӨ-ийн хамгаалалтад хяналт тавихад хандуулагддаг.</p> <p>Түүнчлэн нэмж дурдахад, энэхүү үзүүлэлт нь шинжлэх ухаан, техник, урлагийн судалгааг харуулдаг үзүүлэлт 9-ийг нөхөж байдаг боловч үзүүлэлт 9 нь гол анхаарлаа СББӨ-д өөрт нь анхаарлаа хандуулдаг ба энэ үзүүлэлтийн гол анхаарлын төв нь СББӨ-ийг хамгаалах хөтөлбөр, арга хэмжээний судалгаанд ханддаг байна.</p>
<p>Үйл ажиллагааны үндэслэл</p>	<p>СББӨ-г хамгаалах хөтөлбөр, арга хэмжээний үр нөлөөтэй байдлыг тогтмол хянах, шинжлэх ухаан, техник, уран сайхны судалгаа хийх замаар нэмэгдүүлэх, сайжруулах боломжтой. Иймэрхүү хяналт-шинжилгээ, судалгааг хийх нь ямар хөтөлбөр, арга хэмжээнүүд нь эерэг нөлөөг авчирч байгааг харуулж байдаг. Төрийн бус байгууллагууд болон иргэний нийгмийн бусад байгууллагууд нь ихэвчлэн туршлага, мэдлэгээ нэг дор нэгтгэдэг нь тэдэнд ийм хяналт, судалгаа явуулахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Мөн судалгааны байгууллага, мэргэжлийн төвүүд нь улс орон бүрийн нөхцөл байдлаас шалтгаалан төрийн болон төрийн бус байж болох ба эрдэмтэн, шинжээчид нь төрийн албан хаагч эсвэл хувь хүн ч байж болно. Гэсэн хэдий ч ямар ч тохиолдолд ийм оролцогчид үндэсний түвшинд конвенцийн хэрэгжилтийг хянахад чухал үүрэг гүйцэтгэдэг.</p>

Гол нэр томъёо	<ul style="list-style-type: none"> · Иргэний нийгэм · Идэвхжүүлэх орчин · Олон нийт, бүлгүүд эсвэл зарим тохиолдолд хувь хүмүүс · Шинжлэх ухаан, техник, урлагийн судалгаа · ТББ-ууд · Судалгааны байгууллагууд · Мэргэшсэн төвүүд
-----------------------	---

Хяналт-шинжилгээ хийх, үе үе тайлагнах тухай тусгай заавар

Хяналтын ашиг тус	<p>Энэхүү үзүүлэлтэд хяналт тавих нь анхаарлыг хяналтын үйл явц руу өөрт нь чиглүүлдэг бөгөөд тус үйл явц нь өөрөө СББӨ талаарх үйл ажиллагаануудад оролцож буй иргэний нийгмийн өргөн хүрээний оролцогчдын оролцоо үр шимийг хүртэж байгаа эсэх, мөн тус үйл явц нь янз бүрийн өнцгөөс авч үзэж буй СББӨ-ийн хамгаалалтын судалгаануудаар мэдээллээ сэлбүүлж буй эсэхийг тодорхойлоход тусалж чадна. Энэ үзүүлэлтийг хянах нь эдгээр оролцогчдыг байнгын болон ирээдүйн хяналт, судалгаанд бүрэн оролцуулах бусад боломжуудыг тодорхойлоход боломжтой болгодог. Мөн энэхүү үзүүлэлтийг дэлхийн түвшинд хянах нь хяналтын үйл явцад болон холбогдох судалгаанд иргэний нийгмийг татан оролцуулах үр дүнтэй механизмын жишээнүүдийг санал болгож, улсууд иргэний нийгмийн оролцогчдын мэдлэг, хэтийн төлөвийг ашиглаж байгаа эсэхийг тодорхойлох боломжтой болгодог.</p>
--------------------------	---

Мэдээллийн эх сурвалж, цуглуулга

Энэ үзүүлэлт нь өөрөө мониторингийн үйл явцыг чухалчилдаг тул төрийн нэрийн өмнөөс хяналт тавих, тайлагнах үүрэгтэй хүмүүс өөр өөр түвшинд хяналтын ажилд хувь нэмрээ оруулж буй олон нийт, төрийн бус байгууллага болон бусад оролцогч талуудтай зөвлөлдөх шаардлагатай байж болно. Зөвлөлдөх байгууллага эсвэл зохицуулалтын механизм байгаа энэ нь бол хяналтын үйл ажиллагааг төлөвлөх, хянах, явуулах, үнэлэх олон талт оролцогчдыг нэгтгэх чухал форум болно.

Боломжит мэдээллийн эх сурвалжууд

- Хяналт тавих, тайлагнах үүрэг бүхий байгууллагын ажлын төлөвлөгөө
- Зөвлөлдөх байгууллага эсвэл зохицуулах механизмын ажлын төлөвлөгөө, хэлэлцэх асуудал, тэмдэглэл
- Ном зүй, нийтлэгчдийн каталог эсвэл хэвлэгдсэн бүтээлийн тойм
- Чуулганы хэлэлцэх асуудал эсвэл хуралдааны явц, түүнчлэн төрийн бус байгууллага, иргэний нийгмийн бусад оролцогчдын олон нийтэд танилцуулсан бусад илтгэл, арга хэмжээг тодорхойлсон баримт бичиг
- Төрийн бус байгууллага эсвэл иргэний нийгмийн бусад оролцогчдын хийсэн судалгааны тайлан